



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: БНА-2022/30-ШТА-ГА

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ АСУУДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Баян-Өлгий аймаг 2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хуудас: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хуудас: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Манаргүл Утас: 95429524

Цахим хуудас: manargulx@audit.gov.mn

Аудитор Б.Үүрийнтуяа Утас: 89838414

Цахим хуудас: uuriintuyab@audit.gov.mn

Аудитор Ж.Назгүл Утас: 99668909

Цахим хуудас: nazgulj@audit.gov.mn

Аудитор У.Ербол Утас: 99425121

Цахим хуудас: erbolu@audit.gov.mn

Аудитор Х.Еркебулан Утас: 99999844

Цахим хуудас: erkebulan.Kh@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
ягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС СУМУУДАД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ ТОДОТГОСОН ТӨСВИЙН ХЭМЖЭЭГЭЭР ДУТУУ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА. .8	
1.1. ОНХНС-аас 2021 онд олгох орлогын шилжүүлгийг бүрэн санхүүжүүлсэн байна .8	
1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү? ...8	
Энэ асуулт хамааралгүй болно.....	8
1.1.2. ОНХНС-аас тус аймагт 2021 онд олгох орлогын шилжүүлгийг бүрэн төвлөрүүлсэн байна.	8
1.1.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумуудад олгох орлогын шилжүүлгийг тодотгосон төсвийн хэмжээгээр дутуу төлөвлөсөн байна.....	10
1.1.4. Сумууд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт малын тоо толгойн татварын орлогыг оруулан төлөвлөөгүй байна.....	12
1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.	12
1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сумуудын иргэдийн саналын 67.3 хувь нь дэмжигдсэн байна.	12
1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.	14
1.2.3. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 410.5 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.....	15
1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бусад хууль журмын дагуу төлөвлөсөн байна.	15
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.	16
2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байна.	16
2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулсан байна.....	16
2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	17
2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ зохих үр дүнгээ өгсөн байна.	18
2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна	18
2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд зохих үр дүнгээ үзүүлсэн байна.....	19
2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна	20
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	20
3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт нь зохих түвшинд хүрээгүй байна.	20
3.1.1 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	20
3.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих захиалагчийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	20
3.1.3. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлт 56.7 хувьтай байна.....	22
3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг нэгтгэж тайлагнаагүй байна.	

3.2.1 Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	23
3.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнах асуудал хангалтгүй байна.	23
3.2.3 Удирдлагын мэдээллийн системийн хэрэгжилт хангалтгүй байна.	24
3.2.4 Зарим сумын ОНХС-гаас шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил гаргасан байна.	25
ДҮГНЭЛТ: 26	
ЗӨВЛӨМЖ: 28	
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:	28
БӨА-ТАГ ТУШААЛ	29
ХАВСРАЛТУУД	30
ХАВСРАЛТ 1:	30
ХАВСРАЛТ 2:	30
ХАВСРАЛТ 3:	31
ХАВСРАЛТ 4:	31
ХАВСРАЛТ 5:	32
ХАВСРАЛТ 6:	32

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт	
ААН	Аж ахуйн нэгж	
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага	
ҮАГ	Үндэсний аудитын газар	
ГА	Гүйцэтгэлийн аудит	
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч	
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан	
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	
ЗДТГ	Засаг даргын тамгын газар	
УИХ	Улсын Их Хурал	
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс	
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал	
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль	
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2021 онд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг	
Хүснэгт 2	Аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хуваарилалт	
Хүснэгт 3	ОНХСангийн орлогын шилжүүлэг болон урьд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байдал	
Хүснэгт 4	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл	
Хүснэгт 5	Сумуудын Иргэдээс авсан санал асуулгын судалгаа	
Хүснэгт 6	Худалдан авалттай холбоотой судалгаа	

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан ТАБ-ын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг хороодын ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудит хийх заавар аргачлалыг ашиглан баримт материалыг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Манаргүл, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан, У.Ербол нар хамтран хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2022 оны 04 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авч, талбарын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын дэд тайланг 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор бэлтгэж, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 05-ны дотор нэгтгүүлэхээр хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГААС СУМУУДАД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ ТОДОТГОСОН ТӨСВИЙН ХЭМЖЭЭГЭЭР ДУТУУ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1. ОНХНС-аас 2021 онд олгох орлогын шилжүүлгийг бүрэн санхүүжүүлсэн байна

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?

Энэ асуулт хамааралгүй болно

1.1.2. ОНХНС-аас тус аймагт 2021 онд олгох орлогын шилжүүлгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 7,959.8 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр өөрчлөн баталсан Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 400.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 8,360.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс 358.6 сая төгрөг нь суурь зарлагын санхүүжилт байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүжилтээс 2021 онд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэгийг сум тус бүрээр дараах байдлаар төлөвлөж баталсан байна. /Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

Хүснэгт №1

сая төгрөгөөр

Сумын нэр	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
Дүн	171.4	27.7	199.1

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

Сангийн яамнаас “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.2-т заасны дагуу тус аймагт олгох ОНХС-ийн орлогын шилжүүлэгт үндэслэн сумдын ОНХС-ийн суурь тооцооллыг гаргаж, аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга сумдын ОНХС-д хуваарилах орлогын шилжүүлгийн дүнг тооцохдоо журмын 2.4-т заасан суурь тооцооллын дүн, ОНХС-аас санхүүжих суурь зардал болон Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5-д заасан бусад эх үүсвэрийн хамт 2021 оны төсвийн төсөлд журмын 2.5-д заасан хавсралт маягтын дагуу аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж батлуулсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө, оруулалт, төсөл, арга хэмжээ нэг бүрээр хэлэлцэн Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.7-д заасныг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн IV ээлжит хуралдааны 35 дугаар тогтоолын хавсралтаар аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг дараах байдлаар хуваарилсан байна. /Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу/

Хүснэгт №2

сая төгрөгөөр

№	Аймаг, сум	Хот тохижуулах газрын урсгал зардлын 50 хувь	Малын вакцинажуулалтын зардал	ОНХС-аас олгох урсгал зардлын дүн	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэгийн хуваарилалт	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс	2021 оны 35 дугаар тогтоол /тодотголоор/	2020 оны 16 дугаар тогтоолоор анх төлөвлөсөн	Зөрүү
	НИЙТ ДҮН	21.5	337.1	358.6	27.7	171.2	198.0	147.8	2,075.0	8,001.3	7,601.2	400.5

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2020 оны 16, 2021 оны 35 дугаар тогтоолын хавсралтаас

ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгээс суурь зарлагыг хасаж тооцоход аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 16 дугаар тогтоолоор аймаг, сумын ОНХС-д олгох төсвийг 7,601.2 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 35 дугаар тогтоолоор баталсан төсвийн тодотголоор аймаг, сумын ОНХС-д олгох төсвийг 400.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 8,001.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор нэмсэн 400.5 сая төгрөгийг Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар заалтыг баримтлаагүй зөвхөн аймгийн ОНХСанд нэмж төлөвлөсөн байна. Үүнийг тус аймагт Ковид-19 цар тахлын өвчний тархалт өндөр байсантай холбоотой гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх зардалд хуваарилжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн татварын орлого 2020 онд 8,711.5 сая төгрөгөөр, сумдын орон нутгийн төсвийн татварын орлого 3,141.0 сая төгрөгөөр, нийтдээ 11,852.5 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Алтанцөгц, Бугат, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай, Цэнгэл, Өлгий сумуудын ОНХС-ийн төлөвлөгөөг сумын ИТХ-ын тогтоолоор урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр нийт 537.1 сая төгрөгөөр тодотгон хувиарласан байна. Бусад сум болон аймгийн төсвийн давсан орлогоос ОНХСанд хөрөнгө хуваарилаагүй байна. /Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу/

Хүснэгт №3

сая төгрөгөөр

Аймаг, сумын ОНХСан	Аймгийн ИТХ-аас баталсан дүн	Аймаг, сумын ИТХ-аас тодотголоор баталсан		Батлагдсан төлөвлөгөө
		Урьд оны үлдэгдлээс	2021 оны татварын орлогыг нэмэгдүүлж баталсан дүнгээс хуваарилсан	
Дүн	8,001.3	515.1	-	8,516.4


Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, ОНХС-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сан тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8,001.3 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хүлээн авч, зарим сумуудын ИТХ-аас баталсан урьд оны үлдэгдлээс санхүүжих 515.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, нийт 8,516.4 сая төгрөгөөр үйл ажиллагаа явуулсан байна. Харин орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэн баталж хуваарилсан хөрөнгө байхгүй байна.

Тус аймгийн ОНХС-ийн 2021 оны нийт эх үүсвэрийн 93.7 хувийг ОНХНС-ын орлогын шилжүүлэг, 6.3 хувийг урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэр эзэлж

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн ОНХС-д 2021 онд нийтдээ 8,001.7 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр бүрэн олгосон байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сарын хуваарилалт, бүрдүүлэлтийг графикаар харуулахад дараах байдалтай байна. График №1



Эх сурвалж: Аймгийн CTCХэлтсийн тайлан мэдээ

ОНХНСангаас тус аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой жигд бус олгогдсон байна. Аймгийн CTCХэлтсээс ОНХНСангаас орлогын шилжүүлэг дутуу ирсэн саруудад сумуудад олгох санхүүжилтийг хувь тэнцүүлэн хуваарилж ирсэн байна.

1.1.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумуудад олгох орлогын шилжүүлгийг тодотгосон төсвийн хэмжээгээр дутуу төлөвлөсөн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 16 дугаар тогтоолоор аймаг, сумын ОНХС-д олгох хөрөнгийн хэмжээг Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор баталсан аргачлалаар сум бүрээр хуваарилан тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлж жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлуулна гэснийг баримталж баталсан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.5-д “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь сум, дүүргийн ОНХС-д хуваарилах орлогын шилжүүлгийн дүнг тооцохдоо энэ журмын 2.4-д заасан суурь тооцооллын дүн, ОНХС-аас санхүүжих суурь зардал болон Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4-д заасан бусад эх үүсвэрийн хамт тухайн жилийн аймаг, нийслэлийн төсвийн төсөлд энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ” гэсэн заалтыг баримталж ажилласан байна.

Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “аймаг нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу дараах байдлаар хуваарилна”, 8.1.1-д “ аймаг нь ОНХНС-аас шилжүүлсэн дүнгээс Төсвийн тухай хуулийн 59.2.1-д заасны дагуу суурь зардалд ногдох хэсгийг тухайн сумын ОНХС-д шууд хуваарилна” гэсний дагуу Хот тохижуулах газрын урсгал зардалд 21.5 сая төгрөг, Мал эмнэлгийн вакцинжуулалтын зардалд 337.1 сая төгрөг, нийт 358.6 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн сан болон аймгийн ХХААГ-т журмын дагуу хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.2.4-д “энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй”, Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.1.2-т “аймаг нь энэ аргачлалын 3.3-т заасны дагуу тооцсон эх үүсвэрийг тухайн сум, дүүргийн ОНХС-д шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөнд тооцохгүй” гэсний дагуу олон улсын төсөл, хөтөлбөрөөс олгосон урамшуулалд 27.7 сая төгрөгийг, дэмжлэгт 171.2 сая төгрөгийг, нийт 198.9 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд батлагдсан дүнгээр хуваарилсан байна.

Дээрх аргачлалын 8.2-т “Аймаг нь ОНХНС-аас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг “Төсвийн тухай хуулийн 59.2.2-т “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэсний дагуу сумын ОНХС-д хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1, болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилсан сумыг мөн багтаан тооцно” гэснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аргачлалын 8.3-д энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг тооцохдоо 8.3.1-8.3.3-т заасны дагуу тооцохоор заасан байна.

8.3.1-д “Хүн амын тооноос хамаарах хувь-40 хувь”, 8.3.2-д “Алслалтаас хамаарах хувь-30 хувь”, 8.3.3-т “нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах хувь 30 хувь” гэсний хэрэгжилтийг шалгаж үзэхэд Сангийн яамнаас ОНХНС-аас аймагт хуваарилагдсан дүнг аргачлалын 8.3.1-8.3.3-т заасны дагуу сум бүрээр хуваарилсан байна.

Аймгийн СТСХ-ээс Ногооннуур сумын бүрэлдэхүүнд багтдаг Цагааннуур тосгонд ногдох хэмжээг тооцож хуваарилсан бөгөөд Сангийн яамнаас ирүүлсэн жагсаалтад ямар нэг өөрчлөлт оруулахгүйгээр аймгийн ИТХ-д оруулж батлуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 35 дугаар тогтоолоор аймгийн ОНХСангаас сумдын ОНХСанд хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох орлогын шилжүүлэгт 2,075.2 сая төгрөг, ашигт малтмал, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн 50 хувь гэсэн үзүүлэлтээр 345.8 сая төгрөг хуваарилсан байна.

ОНХНС-аас тус аймагт хуваарилсан орлогын шилжүүлгийн дүнгээс суурь зарлага ба урамшуулал, дэмжлэгт хуваарилсан хөрөнгийг хасаж тооцон 7,443.8 сая төгрөгийн 72.3 хувийг буюу 5,381.6 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 27.7 хувийг буюу 2,062.2 сая төгрөгийг сумуудын ОНХС-д хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 59.2.2-д 30-аас доошгүй хувийг сумуудад хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах гэсэнтэй нийцээгүй байна.

Төсвийн тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр орсон өөрчлөлтөөр 59.2.2-д “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэж заасныг цаашид мөрдөж ажиллах шаардлагатай байна.

ОНХНС-аас тус аймагт хуваарилагдсан 8,360.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн 4.3 хувийг суурь зарлага эзэлж байна. Хуваарилагдсан урамшуулал, дэмжлэгийг оруулж тооцоход сумуудад нийтдээ 2,619.7 сая төгрөг хуваарилагдсан нь ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгээс суурь зарлагыг хасаж тооцсон дүнгийн 35.2 хувийг эзэлж байна. /Судалгааны дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу/

Хүснэгт №4

/ сая төгрөг /

Аймаг, сум	Төлөвлөсөн	Хуваарилсан	Илүү, дутуу
Дүн	8,001.3	8,001.3	0.00

Эх сурвалж: Аймгийн CTCX-ээс авсан судалгаа

Тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн батлагдсан төсөв /суурь зарлагыг хасаж тооцоход/ 8,001.3 сая төгрөг ба гүйцэтгэлээр 8,001.3 сая төгрөг хуваарилсан байна.

1.1.4. Сумууд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт малын тоо толгойн татварын орлогыг оруулан төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуульд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр орсон өөрчлөлтөөр хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсгийн 23.8.15-д “Малын тоо толгойн албан татвар”, 60 дугаар зүйдлийн 60.2-т 60.2.8-д “малын тоо толгойн албан татварын орлого” шинээр нэмэсэн байна.

Энэхүү малын тоо толгойн албан татвар орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулахаар зохицуулсан байна.

Төсвийн тухай хуульд орсон дээрх өөрчлөлтийг баримтлан Алтай Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо сумын, Улаанхус, Цэнгэл сумуудын ИТХ-ын тогтоолоор малын тоо толгойн албан татварын хэмжээг баталж 2021 онд нийтдээ 200.6 сая төгрөгийг сумуудын төсвийн орлогод төвлөрүүлсэн боловч сумын ОНХС-гийн эх үүсвэрт оруулан төлөвлөөгүй байна. Иймд малын тоо толгой татварын орлогыг ОНХС-гийн эх үүсвэрт оруулан төлөвлөж ажиллахыг зөвлөмж болгов.

1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.

1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сумуудын иргэдийн саналын 67.3 хувь нь дэмжигдсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн “Баг, хорооны түвшинд ОНХС-ийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах”, 6 дугаар зүйлийн “Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх”, 7 дугаар зүйлийн “Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх”- хамаарах холбогдох заалтуудын дагуу давхардсан тоогоор сумуудаас нийтдээ 34231 иргэдээс санал асуулга авагдсан байна. /Хүснэгтийн дэлгэрэнгүйг судалгаа 5-аас харна уу/

Хүснэгт: №5

№	Аймаг, сум, дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт санал өгсөн иргэдийн тоо	Нийт санал /ажлаар/		Батлагдсан санал		Цуцлагдсан санал	
		цахим	Бүлгийн ярилцлага	цаасаар		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	3	4	5	6	7=4+5+6	8	9.0	10	11	12	13
	Сумын дүн	298	281	33,652	34,231	443	2,972.2	298	2,539.5	145	432.7

Эх сурвалж: Сумуудын иргэдээс авсан санал асуулгын судалгаа

Алтай сумаас 143.3 сая төгрөгийн 11 ажил, Алтанцөгц сумаас 125.9 сая төгрөгийн 11, Баяннуур сумаас 85.0 сая төгрөгийн 26, Бугат сумаас 125.9 сая төгрөгийн 11, Булган сумаас 216.0 сая төгрөгийн 12 ажил, Буянт сумаас 93.5 сая төгрөгийн 11, Дэлүүн сумаас 223.0 сая төгрөгийн 31, Ногооннуур сумаас 268.2 сая төгрөгийн 25, Сагсай сумаас 159.5 сая төгрөгийн 19, Улаанхус сумаас 214.9 сая төгрөгийн 30, Цэнгэл сумаас 429.1 сая төгрөгийн 41, Өлгий сумаас 312.6 сая төгрөгийн 38, Цагааннуур тосгоноос 50.0 сая төгрөгийн 8 нийтдээ 2,539.5 сая төгрөгийн 298 ажил иргэдээс өгсөн саналын дагуу батлагдсан байна.

Сумуудын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс авсан санал, асуулгын дүнгээс үзэхэд 298 буюу 67.3 хувь нь дэмжигдсэн байна. Сумуудаас Толбо сум ОНХС-гийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авсан санал, асуулга аваагүй байна.

Журмын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн 5.2.2, 5.2.3 дахь заалтын дагуу санал асуулгыг Өлгий сумаас бусад сумууд цахим болон бүлгийн ярилцлага хэлбэрээр санал аваагүй журмын заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөлт, хэрэгжилтийн талаар шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны А/12 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд санал авах ажлын хэсгийн удирдамжийг батлуулан журмын 7.1-дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан боловч хийгдсэн ажлын тайлан, үр дүнгийн талаар ямар нэг нотлох зүйл байхгүй байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг аймгийн Иргэний танхимаар дамжуулан олон нийтэд зар мэдээ хүргэж олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байгаа нь журмын 7.5 -д “Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 7 дугаар сард багтаан 2-оос доошгүй удаа зохион байгуулна”, 7.6-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хамгийн олон санал авсан, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Аймгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй 2,583.4 сая төгрөгийн өртөгтэй 104 төсөл арга хэмжээг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс 2021 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтад оруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралтаар батлуулан хэрэгжүүлсэн байна.
- Алтанцөгц сум 47.5 сая төгрөгийн 6, Баяннуур сум 17.5 сая төгрөгийн 7, Булган сум 10.7 сая төгрөгийн 3, Дэлүүн сум 51.0 сая төгрөгийн 4, Ногооннуур сум 260.2 сая төгрөгийн 37, Толбо сум 80,8 сая төгрөгийн 7 нийтдээ 473.7 сая төгрөгийн 64 төсөл арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад жагсаалтад оруулж сумын ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4, 60.3.6, 63 дугаар зүйлийн 63.1, 63.2, 63.3, 63.4 дахь заалт, Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар хэсгийн 3.1.2, 5-р хэсгийн 5.6, 6 дугаар хэсгийн 6.7, 6.8, 10 дугаар хэсгийн 10.2, 10.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитын дүнгээр дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар аймгийн ХОХБТХэлтэс болон Алтанцөгц, Баяннуур, Булган, Дэлүүн, Ногооннуур, Толбо сумуудын ҮДТГ-т гэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж санхүүжүүлэхгүй байх талаар албан шаардлага өгөгдлөө.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.

Аймгийн Засаг даргын ажлын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж 2020 оны 12 дугаар сард төсвийн төслийн хамт аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны II хуралдааны 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг баталжээ.

Тогтоолын хавсралтад 2018-2021 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 875.2 сая төгрөгийн 17 шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, 2021 онд шинээр эхлэх 4,127.8 сая төгрөгийн 150 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ буюу нийт 4,981.0 сая төгрөгийн 167 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн ээлжит V хуралдааны “2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар 2021 онд шинээр хийгдэх бусад төсөл арга хэмжээний зардалд Гамшгаас урьдчилан сэргийлэх зардлыг 350.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 50.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг нэмж нийтдээ 400.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,381.5 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит VI хуралдааны “Аймгийн 2021 оны төсвийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулж, зарцуулах зөвшөөрөл олгох тухай” 50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2021 онд шинээр хийгдэх төсөл арга хэмжээнээс 68.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний нэрийг өөрчилж,

Гамшгаас урьдчилан сэргийлэх зардлаас 45.0 сая төгрөгийг бууруулж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд шилжүүлэн зарцуулахаар, Өлгий сумын 10 дугаар багийн цахилгааны трансформатор тавих 30.0 сая, Өлгий сумын 5 дугаар багийн зам засвар 20.0 сая, Дэлүүн сумын 7 дугаар багийн өвөлжөөнд гүний худаг гаргах 9.8 сая, багш нарын спортын арга хэмжээнд 5.0 сая нийтдээ 64.8 сая төгрөгийн ажил хасагдаж,

Өлгий сумын 6, 9 дүгээр багийн гүний худгийн нэмэлт ажил 20.0 сая, Нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын станцад кабель татах ажил 19.8 сая, Батлан хамгаалах газрыг бэхжүүлэх материалын нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажилд шаардагдах санхүүжилт 10.0 сая, Дэлүүн сумын 12 дугаар багт худаг гаргах ажил 15.0 сая төгрөгийн 5 арга хэмжээг шинээр нэмж өөрчлөн баталсан байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасныг баримталж Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй уялдуулсан байна.

Сумуудын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулсан байна.

1.2.3. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 410.5 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд аймгийн ОНХС-ийн төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсгийн 58.2.1-58.2.20 дахь заалтуудаар аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамаарах 4,811.2 сая төгрөгийн 158 төсөл, арга хэмжээг тусгаж хэрэгжүүлсэн боловч зарим төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээнүүд байна.

Тухайлбал: аймгийн Тусгай чиг үүргийн байгууллагуудад эд хогшил, тоног төхөөрөмж, урсгал засварын ажилд 166.7 сая төгрөгийн 15, хөшөө дурсгал сэргээн засварлахад 22.8 сая төгрөгийн 2, тээврийн хэрэгсэл автомашин, мотоцикл авахад 65 сая төгрөгийн 3, шүүхийн шийдвэр болон бусад урсгал засварын зардалд 156.0 сая төгрөгийн 6 нийтдээ 410.5 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4 дэх хэсгийн 58.4.1-58.4.11 дэх заалтын хүрээнд Алтай сум 147.2 сая төгрөгийн 14 ажил, Алтанцөгц сум 120.4 сая төгрөгийн 10, Баяннуур сум 63.9 сая төгрөгийн 24, Бугат сум 112.9 сая төгрөгийн 22, Булган сум 416.4 сая төгрөгийн 37, Буянт сум 96.7 сая төгрөгийн 10, Дэлүүн сум 293.9 сая төгрөгийн 38, Ногооннуур сум 474.7 сая төгрөгийн 57, Сагсай сум 159.5 сая төгрөгийн 19, Толбо сум 144.7 сая төгрөгийн 14, Улаанхус сум 214.9 сая төгрөгийн 30, Цэнгэл сум 436.4 сая төгрөгийн 41, Өлгий сум 463.4 сая төгрөгийн 38, Цагааннуур тосгон 49.9 сая төгрөгийн 9 нийтдээ 3,194.9 сая төгрөгийн 363 төсөл, арга хэмжээг сумдын Засаг даргын чиг үүрэгт хамааруулан төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-д хийсэн аудитын дүнгээр аймгийн Засаг даргын чиг үүрэгтэй хамааралгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчлүүдийг арилгах талаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т албан шаардлага өгөгдсөн болно.

1.2.4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бусад хууль журмын дагуу төлөвлөсөн байна.

ОНХС-гаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, 60.3.1, 60.3.2, 60.3.3, 60.3.4, 60.3.6 заалтуудтай нийцүүлж төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3-д “Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална”, 6.3.1-д “Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах”, 6.3.2-д “орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөхгүй байх”, 6.3.3-т “хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх”, 6.3.4-д “орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх”, 6.3.5-д “иргэдийн оролцоог хангасан байх”, 6.3.6-д “зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр эх үүсвэртэй давхардуулахгүй байх” зэрэг заалтуудад үндэслэн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу төлөвлөсөн байна. Харин бусад хууль журмын дагуу төсөл арга хэмжээ төлөвлөөгүй байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд нийтдээ шилжих хөрөнгө оруулалтаар 1,399.0 сая төгрөгийн 87, шинээр эхлэх 6,995.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 431 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,730.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 15 ажлын гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 2,373.0 сая төгрөгийн өртөгтэй 67 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, 2,703.8 сая төгрөгийн өртөгтэй 326 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд гэрээгээр, 69.4 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотойгоор худалдан авалтыг зохион байгуулж, харин 119.9 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлаагүй байна. /Хүснэгтийн дэлгэрэнгүйг судалгаа 5-аас харна уу/

Хүснэгт №06

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Төлөвлөсөн ажил		Нээлттэй тендер шалгаруулалт					
		Шинэ оны ажил				Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Нийт дүн	431	6,995.8	15	1,730.1	67	2,373	326	2,703.8

Эх сурвалж: ОНХС-гийн 2021 оны тендерийн баримт материалаас

Сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 299 төсөл, арга хэмжээний 261 төсөл, арга хэмжээг буюу 90 %-ийг шууд гэрээгээр хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг аймгийн Орон нутгийн өмчийн газар, сумуудын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг сумын ЗДТГ холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер шалгаруулалт болон үр дүнг www.tender.gov.mn цахим сайтад тухай бүр байршуулан ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу захиалагчаас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн А-З сертификаттай хүнийг оруулж, 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тендерийн баримт бичгийг худалдан авах ажлын төрөл болон худалдан авах ажиллагааны хэлбэрээс шалтгаалан Сангийн яамнаас баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт, тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлалын дагуу бэлтгэн боловсруулан цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлэн ажилласан байна.

Гэвч тендерийн баримт бичгийг хууль тогтоомж, журамд нийцүүлээгүйгээс Сагсай сумын 80 хүүхдийн дотуур байрны их засварын ажлын тендерийн бичиг баримттай холбоотой “Эба

констракшн"ХХК -аас Сангийн яамд, Өлгий сумын 2 дугаар бага сургуулийн засварын ажлын тендерийн бичиг баримттай холбоотой "Жайык" ХХК-аас Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаж, шүүхээс хариуцагч талд шийдвэрлэсэн байна.

Мөн Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 оноос шилжиж ирсэн болон 2021 онд хэрэгжсэн 96.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 багийн гэрэлтүүлгийн ажлыг 10 ажил болгон салгаж шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн,

Өлгий сумын 1, 4, 5, 6, 9, 11 дүгээр баг болон ногоон байгууламжийн хашаанд 8 ширхэг гүний худаг шинээр гаргах төсөл арга хэмжээний нийт төсөвт өртгийг 8 ажил болгож 3 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 46 дугаар зүйлийн 46.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна", 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах" гэсэн заалтуудад нийцээгүй байна.

Аудитаар Өлгий сумын ЗДТГ-т ижил төрлийн төсөл арга хэмжээг нэг багц болгож нээлттэй тендер зарлах, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн хэмжээний ОНХС-ийн данс нь оны эхэнд 701.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба ОНХС-аас 8,001.3 сая төгрөгийн орлогын шилжүүлэг, бусад орлогоос 27.2 сая төгрөгийн бүгд 8028.5 сая төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр 7,533.2 сая төгрөгийг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зарцуулж оны эцэст 1,196.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. ОНХС-гийн оны эцсийн үлдэгдэл оны эхнээс 495.3 сая төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой гамшгийн арга хэмжээний зардал хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна.

Аймгийн хэмжээгээр ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийтдээ 8567.8 сая төгрөгийн өртөгтэй 521 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 7959.6 сая төгрөгийн 484 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч байгууллага, иргэдтэй гэрээ байгуулж ажилласан байна.

Үүнээс 7,300.3 сая төгрөгийн 473 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 540.0 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. Бүрэн хэрэгжсэн 473 төсөл арга хэмжээнээс 35 төсөл, арга хэмжээний 766.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна. Энэ нь зарим хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэнтэй холбоотой ба аймаг, сумын дүнгээр нийтдээ 380.7 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байгаагийн 6 нь Ногооннуур сумын, 10 нь аймгийн ОНХС-аас хэрэгжээгүй төсөл хөтөлбөрүүд байна. Энэ нь ковид-19 цар тахлын үед хөл хорио тогтоосон, хил хаагдсанаас барааны үнэ өссөн, зарим бараа материалын хомсдолд орсонтой холбоотой байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг шалгахад аймгийн ОНХС-аас зориулалт бус зарцуулсан зөрчил дутагдал илрээгүй, харин зарим сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг шалгаж дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Алтай сумын ИТХ-ын хуралдаанаас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс хамтарсан багийн арга хэмжээнд 5.0 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсний дагуу сумын Засаг даргын захирамжаар 3.9 сая төгрөгийг зорилтод бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэг удаагийн буцалтгүй тусламж болгон олгосон.

- Ногооннуур сумын ОНХС-гаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд хийсэн ажлын тайлан, анхан шатны нотлох баримтгүйгээр 1.2 сая төгрөг олгосны дээр Засаг даргын тамгын газрын урсгал засварын ажлын гүйцэтгэлд гэрээний дүнгээс 0.2 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон.
- Дэлүүн сумын Засаг даргын 2021 оны А/19 тоот захирамжаар Наурызын баярын арга хэмжээнд 5.0 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Аудитын дүнгээр Алтай, Ногооннуур сумуудад зориулалт бус зарцуулсан 5.3 сая төгрөгийг төлүүлэхээр акт тогтоож, Дэлүүн сумд 5.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ зохих үр дүнгээ өгсөн байна.

2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд бүрэн хэрэгжиж дууссан 5,978.1 сая төгрөгийн 272 төсөл арга хэмжээ нь орон нутгийн байгууллага, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын засвар, хатуу, зөөлөн эдлэл, тоног төхөөрөмжөөр хангах, гэрэлтүүлэг, цахилгаан трансформатор тавих, гүүр болон зам, замын засвар, гүний худаг гаргах, үүрэн холбооны сүлжээ, гамшгаас хамгаалах зардал зэрэг иргэдийн болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бодит үр дүнгээ өгсөн төсөл арга хэмжээнүүдийн заримаас нь дурдвал:

- Сургуулийн болон хүүхдийн цэцэрлэгийн хүүхдийн сурах орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор нэг бага сургууль, хоёр цэцэрлэгийн барилга шинээр баригдаж, 18 сургууль, цэцэрлэгийн засвар, хүүхдийн тоглоомын 10 талбай ашиглалтад оржээ.
- Эрүүл мэндийн салбарын барилга, байгууламжийн засвар хийх, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжаар хангах 16 ажил хийгдсэнээр эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах, үйл ажиллагаанд дэмжлэг болсон байна.
- Аймгийн хэмжээнд нийтдээ 33 байршилд цахилгааны трансформатор тавих, гэрэлтүүлгийн ажил хийгдсэнээр тухайн нутаг дэвсгэрийн ард иргэдийн гэрэл цахилгааны асуудал шийдэгдэж, иргэдийн аюулгүй амьдрах орчин сайжирсан байна.

Аудитын дүнгээр аймаг, сумын ОНХС-гаас дараах нийтлэг зөрчил дутагдлууд илэрсэн. Үүнд:

- Аймаг, сумын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хэт жижиглэж хуваарилж, баталж байгаа нь ОНХС-гийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг бууруулсан байна.
- Аймаг, сумын ИТХ-аас ихэвчлэн аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарын сонгогдсон тойрогт зориулсан ажлуудыг дэмжин батлуулж байгаа нь иргэдийн санал аваагүй, олон нийтийн эрх ашигт нийцээгүй ажлууд батлагдахад нөлөөлсөн байна.
- Аймгийн төвд жил бүр айл өрхийг цэвэр усны шугамд холбох, гүний худаг гаргах ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлж байгаа боловч үр дүн багатай байна. Өлгий сумын багуудад хийгдсэн цэвэр усны шугамд холбогдсон айл өрхийн тоо төлөвлөснөөс бага байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. 2021 онд 2, 8 дугаар багт хийгдсэн цэвэр усны шугамд 13 айл өрх холбогдсон нь хангалтгүй байна.
- Журмын 4.2-т “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно”, 4.2.5-т “Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал” гэж заасан боловч улсын төсвийн байгууллагуудад сангийн хөрөнгөөр тоног

төхөөрөмж, эд хогшил худалдан авах, тусгай шилжүүлгийн байгууллагуудад урсгал зардалд зарцуулах зөрчил давтагдан гарсан байна.

Мөн зарим барилгын ажлын хөрөнгийн эх үүсвэрийг 2-3 жил дамжуулан хувааж төлөвлөж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд зохих үр дүнгээ үзүүлсэн байна.

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд нийтдээ 7,959,6 сая төгрөгийн 484 төсөл арга хэмжээ хэрэгжүүлснээс 4,701.4 сая төгрөгийн хөрөнгө бий болж үүнээс 75.6 хувийг буюу 3,552.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээг хөрөнгийн төрлөөр авч үзвэл барилга засврын ажил 18.1 хувь буюу 1,443.7 сая, зам засвар, гүүрийн ажилд 13.0 хувь буюу 1,034.1 сая, гэрэлтүүлэг, трансформатор тавих ажилд 13.7 хувь буюу 1,090.9 сая, гүний худаг, цэвэр усны шугам татах ажилд 7.2 хувь буюу 572.7 сая, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэх ажилд 4.5 хувь буюу 355.2 сая, үүрэн холбооны сүлжээнд 2.6 хувь буюу 204.8 сая, бусад төсөл арга хэмжээнд 40.9 хувь буюу 3,258.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээний ихэнх хувийг эзэлж байгаа бусад төсөл арга хэмжээнд гамшигаас урьдчилан сэргийлэх, Хот тохижуулах албаны зардал, өвс тэжээлийн нөөц бэлтгэх, Ногооннуур сумын Ковш-50 тээврийн хэрэгсэл, “Суат”ХХК-д тусгай зориулалтын Пикап машин, аймгийн ЗДТГ-т ковидын тандалт судалгааны тээврийн хэрэгсэл, тусгай чиг үүргийн байгууллагуудад харуулын байр барих, тоног төхөөрөмж, бохир цэвэр усны засвар, дулааны шугам солих болон бусад төсөл арга хэмжээнүүд багтаж байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 160.5 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ дутуу буюу чанаргүй хэрэгжсэн, 1,148.1 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд орлого авч бүртгэл тайланд тусгаагүй байна.

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтын байдлыг шалгаж үзэхэд:

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр худалдаж авсан Ногооннуур суманд Ковш-50 тээврийн хэрэгсэл нь эвдэрч ашиглах боломжгүй болсноос аймгийн Авто тээврийн газарт техникийн дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан,
- Толбо сумын ЗДТГ-т “ЗДТГ-ын албаны хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ”-ний дагуу гүйцэтгэгч “Шинжанбек” ХХК-наас 4 нотвүүк хүлээн авсан боловч гадна тал нь ховхорсон, чанаргүй тоног төхөөрөмжийг нийлүүлсэн,
- Цагааннуур тосгоны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Эрүүл мэндийн төвд “Рискос” ХХК-аас нийлүүлсэн 10.0 сая төгрөгийн биохимийн аппарат нь эвдэрхий, ашиглах боломжгүй,
- Өлгий сумын Ногоон байгууламжийн хашааны 1, 2 дугаар гүний худгуудыг хариуцах эзэнгүй, харуул хамгаалалтгүй учраас гүний худгийн мотор нь хулгайд алдагдсан, Өлгий сумын 6, 11 дүгээр багийн гүний худаг ашиглагдаагүй, 4 дүгээр багийн худгийг ганц айл

ашиглаж байгаа нь хөрөнгө оруулалтын зорилгод нийцээгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна.

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэж заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан ашиглагч байгууллагууд нь хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцаж зориулалтын дагуу ашиглаж байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт нь зохих түвшинд хүрээгүй байна.

3.1.1 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4-т аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагатай хамт орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахаар, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2-т аймаг, сумын ИТХ-ын чиг үүргийг тодорхойлж 3.2.2-т “Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавина” гэж заасан боловч аймаг, сумын ИТХ нь энэхүү чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүнгээр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллахыг зөвлөмж болгов.

3.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих захиалагчийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-гаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтыг Барилга захиалагчийн албанд хариуцуулж, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд Барилга захиалагчийн алба нь 3,058.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 95 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, барилга, их засварын ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн эсэх, ажлын явц болон гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Хяналтыг хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ бүрд “Захиалагчийн техникийн нэгдсэн дүгнэлт” гарган, тайлан бичиж, Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад авах комисс”-ын бүрэлдэхүүнд орж ажилласан байна.

Аудитын явцад захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж үзэхэд “Жайых” ХХК -ы гүйцэтгэсэн Өлгий сумын 2 дугаар бага сургуулийн засварын ажлын санхүүжилтийг бүрэн авсан боловч засварын ажил хангалтгүй байгаа нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байгаатай холбоотой тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.3-т “Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалтыг үндэслэн сумдын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тайланд онд 1-2 удаа захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан боловч зарим хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүдэд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Сумуудын ОНХС-гаас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдтэй захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Алтанцөгц сум: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 10.0 сая төгрөгийн Хүүхдийн парк, 8.0 сая төгрөгийн Хүүхдийн паркийн тоглоомын ажилд 13.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид олгосон боловч нийлүүлсэн хөрөнгө нь чанаргүй, ажил нь дутуу хийгдсэн.
- Баяннуур сум: 3.0 сая төгрөгийн гүүрний засвар, 3.0 сая төгрөгийн өвөлжөөний хоёр талд далан барих ажлууд дутуу хийгдсэн, гэрээний хэрэгжилт хангалтгүй.
- Булган сум: Улаагчин багийн 4.0 сая төгрөгийн Хөшөөтийн хадлангийн талбай хаших, 4.0 сая төгрөгийн “шуудууны эх гаргах” ажлууд дутуу хэрэгжсэн, гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээний хугацаа дууссан боловч ажил дүгнэх комисст хүлээлгэж өгөөгүй.
- Буянт сум: сумын төвийн авто зогсоол барих 40.4 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчид 32.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил нь гэрээнд заасны дагуу бүрэн хийгдээгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй.
- Дэлүүн сум: Ахмадын хорооны үйл ажиллагаанд ашиглах 5.0 сая төгрөгийн хуучин эмнэлгийн өрөөнүүдийн засварын ажил, 5.0 сая төгрөгийн Чихэртэй багийн бүргэдийн замын засвар, 10.0 сая төгрөгийн хогийн отвал байгуулах ажлууд дутуу хэрэгжсэн, гэрээний хугацаа дууссан боловч ажил дүгнэх комисст хүлээлгэж өгөөгүй, Онцгой байдлын газрын салбарын засварын ажлыг комисс хүлээж аваагүй байхад гүйцэтгэгчид 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.
- Ногооннуур сум: Өмнөх оноос дамжих ирсэн 59.6 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, 2021 онд гэрээ байгуулсан 27.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд нийт 58.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй.
- Толбо сум: “Толбо сумын өвс тэжээлийн нөөцөд боодолтой өвс нийлүүлэх” ажилд 16.0 сая төгрөг, “Арьс ширний цех барих, тоног төхөөрөмж нийлүүлэх” ажилд 16.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч хэрэгжилтийг хангуулаагүй, ИТХ-д тоног төхөөрөмж нийлүүлэх 3.8 сая төгрөгийн ажлыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй.
- Цэнгэл сум: сумын төвийн 9-р багт хүүхдийн тоглоомын талбай барих 14.0 сая төгрөгийн ажилд 4.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил нь бүрэн хийгдээгүй.
- Өлгий сум: Төсөл арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь шалгаж үзэхэд 1, 5, 11 дүгээр багийн гүний худгийг айлын хашаанд дотор гаргаснаас иргэд ашиглах боломжгүй болсон, 4 дүгээр багийн худгийг ганц айл ашиглаж байгаа, Ногоон хашаанд гүний худаг гаргах ажлын гэрээг хийснээс 2 хоногийн дараа ашиглалтад оруулснаар баримт бүрдүүлсэн нь хөрөнгө оруулалтын зорилгод нийцээгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон.

- 12 дугаар багийн биеийн тамирын талбайн засварын ажил чанаргүй хийгдсэн, Шинэ захын замын дагуу шинээр барьсан 2 автобусны зогсоол нь зураг төсвийн дагуу хийгдээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн 1365300,0 мянган төгрөгийн өртөгтэй 42 төсөл хөтөлбөрийн гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн байна.

Аудитын дүнгээр дээрх аймгийн ХХОХБХэлтэс болон сумуудын Засаг дарга нарт зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3.1.3. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлт 56.7 хувьтай байна.

Тус аудитын газраас ОНХС-гийн зарцуулалтад 2020 онд хийсэн нийцлийн аудитаар 7.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 4 акт тогтоож, 5286.6 сая төгрөгийн зөрчилд 17 албан шаардлага, 6 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад өгсөн байна.

Аймаг, сумдын ЗДТГ-ууд өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд гаргаж ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлагын хэрэгжилтийг энэхүү аудитаар давтан шалгаж үзэхэд төлбөрийн акт 100 хувь барагдсан бөгөөд албан шаардлагын биелэлт 56.7 хувьтай хэрэгжсэн байна.

Үүнээс албан шаардлагыг Сагсай сум 90 хувь, Улаанхус сум 85 хувь, Буянт сум 80 хувь, Алтай, Бугат, Цагааннуур, Цэнгэл сум 70 хувь, Толбо, Булган, Өлгий сум, Баяннуур, Дэлүүн сум 60 хувь, Ногооннуур 40 хувьтай хэрэгжүүлж, Алтанцөгц сумын албан шаардлагын биелэлт хангагдаагүй 0 хувьтай байна.

Бугат сумын Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад 2020 онд хийсэн нийцлийн аудитаар Ерөнхий боловсролын сургуульд бөхийн дэвжээ нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Хүйтэн хошуу” ХХК-д урьдчилгаанд 6.1 сая төгрөг шилжүүлсэн боловч хөрөнгийг нийлүүлээгүй байсан зөрчилд албан шаардлага өгөгдсөн бөгөөд сумын Засаг даргын зүгээс албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй, зөрчлийг арилгаагүй байгаа тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас Баяннуур, Бугат, Булган, Дэлүүн, Толбо, Улаанхус сумуудын ОНХС-ийн 2021 оны зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн бөгөөд аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

Энэ удаагийн аудитаар илэрсэн зөрчлийг өмнөх онуудад илэрсэн зөрчилтэй харьцуулж үзэхэд иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг жагсаалтад оруулан баталж хэрэгжүүлсэн, үр өгөөж багатай төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд орлого аваагүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсан байна.

Аймаг, сумын ОНХС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн аудитын дүнгээр илэрсэн зөрчлийг 2020 онд хийсэн аудитаар илэрсэн зөрчилтэй харьцуулахад зөрчлийн мөнгөн дүн 1430.8 сая төгрөгөөр буюу 27.0 хувиар өссөн байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг нэгтгэж тайлагнаагүй байна.

3.2.1 Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3 аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сумдаас гаргуулан авч, дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулах үүрэгтэй юм.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь “ОНХС-ийн 2021 оны хэрэгжилт, 2021 оны саналын танилцуулга” сэдвийн дагуу ард иргэдэд танилцуулга зохион байгуулсан байна. Гэвч Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний явцын тайлан, мэдээг сум бүрээр гаргуулан авч, дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар нэгдсэн тайлан бэлтгэж гараагүй байна.

Мөн журмын 9.9-д заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн талаар жилийн тайланг нэгтгэж 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст хүргүүлээгүй байна.

Аудитын дүнгээр журмын 9.9 дэх заалтыг хэрэгжүүлж ОНХС-ийн хэрэгжилтийн талаар нэгдсэн тайлан бэлтгэж ажиллахыг албан шаардлага болгов.

3.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнах асуудал хангалтгүй байна.

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн үр дүнд хөрөнгийг ашиглалтад оруулах комиссын актын үндэслэн ашиглагч байгууллагуудад орлого авч данс бүртгэлд тусгаж байгаа боловч аймгийн болон зарим сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд орлого авч бүртгэл тайланд тусгаагүй байсан дараах зөрчил илэрч албан шаардлага өгөгдлөө. Тухайлбал:

Алтанцөгц сумын 3 дугаар багт шинээр тавьсан 44.9 сая трансформатор, Улаанхус сумын 8 дугаар багт шинээр тавьсан 20.0 сая төгрөгийн өртөгтэй 2 ширхэг трансформатор, Ногооннуур сумын Ховд багт тавьсан 16.7 сая төгрөгийн трансформатор, Бугат сумын тэжээлийн фондод нийлүүлсэн 5.0 сая төгрөгийн өвс, Дэлүүн сум тэжээлийн фондод нийлүүлсэн 42.3 сая төгрөгийн өвс, Цагааннуур тосгоны тэжээлийн фондод нийлүүлсэн 5.0 сая төгрөгийн хивэг, өвс, Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 5.0 сая төгрөгийн тавилга, Цэнгэл сумын Руханият сургуулийн 15.0 сая төгрөгийн тоглоомын талбай, Ногооннуур сумын Бахлаг багийн худгийн мотор, геодезийн цэг болон сумын төвийн хаягжуулалтыг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн аймгийн болон зарим сумын ОНХС-гаас тооцоогоор үүссэн 1,021.9 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан нийтдээ 673.5 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагуудын данс бүртгэлд орлого авч данс бүртгэлд тусгаагүй,

- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Алтай, Толбо, Ногооннуур сумуудын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын урьдчилгаанд олгосон 180.0 сая төгрөг, Толбо сумын Соёлын төвийн барилгын хөрсний геологийн судалгааны ажлын хөлсөнд олгосон 3.2 сая төгрөгийг гэрээний 4.1-т эргэн төлөхөөр заасан боловч санхүүгийн тайланд авлагаар бүртгэж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

- Ногооннуур сум өмнөх оноос дамжих ирсэн 59.6 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, 2021 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 27.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд нийт 58.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй, дараа онд шилжсэнийг санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй байна.

- “Толбо сумын өвс тэжээлийн нөөцөд боодолтой өвс нийлүүлэх” ажлын гэрээний урьдчилгаанд 16.0 сая төгрөг, “Арьс ширний цех барих, тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гэрээний урьдчилгаанд 16.0 сая төгрөг, Толбо сумын төвийн 2.31 км авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам, сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын 10.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн боловч гэрээний хугацаа дууссан, гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй.

- Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр “Файвер оптик” ХХК гүйцэтгэсэн “Толбо сумын 3, 4 дүгээр багуудыг 4G сүлжээнд холбох ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн актаар тус сумын ЗДТГ-т 39.5 сая төгрөгийн хөрөнгийг падаанаар хүлээлгэн өгсөн боловч орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.

3.2.3 Удирдлагын мэдээллийн системийн хэрэгжилт хангалтгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2-т заасны дагуу аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд оруулж, ил тод мэдээлэх журамтай юм.

Аудитаар журмын дээрх заалтын хэрэгжилтийг шалгаж үзэхэд Алтай, Баяннуур, Өлгий сум 2021 оны мэдээллээ бүрэн оруулсан бол Алтанцөгц, Ногооннуур, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумууд мэдээллээ дутуу оруулсан байна.

Харин аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Толбо сумууд ОНХС-гийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар Удирдлагын мэдээллийн системд ямар нэгэн мэдээлэл оруулаагүй байна.

Иймд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд оруулаагүй аймгийн болон сумдын ОНХС-гийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг аймгийн ХОХБТХ, СТСХ болон сумын Засаг дарга нарт албан шаардлага болгов.

3.2.4 Зарим сумын ОНХС-гаас шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчил гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн ил тод байдлын хангалтыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар горим сорил хэрэгжүүлж илэрсэн зөрчлийг арилгах талаар холбогдох сумын албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

Тухайлбал: Булган сумд 1054.0 сая төгрөгийн, Дэлүүн сумд 561.4 сая төгрөгийн, Ногооннуур сумд 489.3 сая төгрөгийн, Толбо сумд 191.8 сая төгрөгийн, Улаанхус сумд 109.1 сая төгрөгийн, Өлгий сумд 350.6 сая төгрөгийн, нийтдээ 2756.2 сая төгрөгийн ОНХС-ийн мэдээллийг шилэн дансанд байршуулан мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Бусад сумууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллээ хугацаанд нь оруулж, хууль журмыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймаг, сумын ОНХС-ийн бүрдүүлэлт зарцуулалт, үр нөлөө, үр дүнд хийсэн энэхүү гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 6725,0 сая төгрөгийн зөрчил илэрч 11.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6313,1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар аймгийн ИТХурал болон аймгийн Засаг даргад 5 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг бүрэн санхүүжүүлсэн байна
2. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт орон нутгийн орлогоос хөрөнгө нэмж төлөвлөөгүй байна
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна
4. Аймгийн ОНХС-аас чиг үүрэгт хамааралгүй 410.5 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна
5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байна
6. ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөж хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд тавих хяналт нь зохих түвшинд хүрээгүй байна.
7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ зохих үр дүнгээ өгсөн байна
8. ОНХС-ийн хэрэгжилтэд тавих хяналт, үр дүнг тайлагнах асуудал хангалтгүй байна



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264

2022.06.07 №

8-03/527

танай _____ -ны № _____ -т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Танай байгууллагаас 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлантай танилцав. Аудитыг холбогдох хууль, журмын дагуу хийсэн гэж үзэж байна.

Тайлантай холбоотой ямар нэгэн санал байхгүй.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.АНАР

0108221147

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн ИТХ-ын дарга Н.Бейбитхан-д:

1.Орон нутгийн төсвийн төслийг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхдээ аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нэг бүрээр хэлэлцэж, иргэд, олон нийтийн саналаар дэмжигдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төсөвт тусгаж батлуулахгүй байх;

2. Орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамааралгүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд хөрөнгө хуваарилж батлуулахгүй байх арга хэмжээ авах анхаарах;

3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллах;

II. Аймгийн Засаг дарга Д.Бауыржан-д:

1. Сумууд ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтыг баримталж малын тоо толгой татварын орлогыг төлөвлөж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, үр дүнг тооцож ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

ОНХС-гийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох журамд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар Улсын Их Хурал, Сангийн яаманд хүргүүлэхээр санал болгож байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн өгсөн саналыг орхигдуулах аймаг, сумын ЗДТГ-аас эрэмбэлсэн жагсаалтад оруулахгүй байгаа зөрчил арилахгүй байгаа тул энэхүү зөрчилд хүлээлгэх хариуцлагын асуудлыг Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журамд тодорхой тусгаж оруулах

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хэт жижиглэсэн төсөл арга хэмжээнд хуваарилж төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь орон нутгийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж, үр дүнгүй болгож байгаа асуудлыг Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн журамд тодорхой тусгаж оруулах шаардлагатай байна.

БӨА-ТАГ ТУШААЛ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/14

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/ болон холбогдох байгууллагуудын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /Х.Манаргүл/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

ХАВСРАЛТУУД**ХАВСРАЛТ 1:**

2021 онд сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэгийг сум тус бүрээр:

	Сумын нэр	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
1	Алтай сум	10.1	27.7	37.9
2	Алтанцөгц сум	5.0	-	5.0
3	Баяннуур сум	10.2	-	10.2
4	Бугат сум	5.0	-	5.0
5	Булган сум	21.1	-	21.1
6	Буянт сум	5.6	-	5.6
7	Дэлүүн сум	20.6	-	20.6
8	Өлгий сум	23.8	-	23.8
9	Ногооннуур сум	18.0	-	18.0
10	Сагсай сум	8.3	-	8.3
11	Толбо сум	8.6	-	8.6
12	Улаанхус сум	15.6	-	15.6
13	Цэнгэл сум	19.3	-	19.3
	Дүн	171.4	27.7	199.1

ХАВСРАЛТ 2:

Аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хуваарилалт

№	Аймаг, сум	Хот тохижуулах газрын урсгал зардлын 50 хувь	Малын вакцинжуулалтын зардал	ОНХС-аас олгох урсгал зардлын дүн	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэгийн хуваарилалт	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Хүн амын нягтрал, алслагд, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс	2021 оны 35 дугаар тогтоол /тодотголоор/	2020 оны 16 дугаар тогтоолоор анх төлөвлөсөн	Зөрүү
1	Алтай		27.8	27.8	27.7	10.1		2.6	122.5	162.9	162.9	
2	Алтанцөгц		21.3	21.3		4.9	42.9	6.5	60.0	114.3	114.3	
3	Баяннуур		20.6	20.6		10.2			123.9	134.1	134.1	
4	Бугат		17.8	17.8		5.0	42.8		60.7	108.5	108.5	
5	Булган		19.8	19.8		21.1	0.4	4.4	256.0	281.9	281.9	
6	Буянт		23.3	23.3		5.6	19.4		68.4	93.4	93.5	
7	Дэлүүн		31.2	31.2		20.6	19.9	3.8	249.6	293.9	293.9	
8	Ногооннуур		37.4	37.4		18.0	30.1	27.9	218.5	244.6	244.7	
9	Сагсай		33.2	33.2		8.3	18.3	32.4	100.5	159.5	159.5	
10	Толбо		31.8	31.8		8.7		31.9	104.1	144.7	144.8	
11	Улаанхус		30.5	30.5		15.6	0.9	9.1	189.1	214.7	214.9	
12	Цэнгэл		36.9	36.9		19.3	22.6	29.2	233.2	304.3	304.3	
13	Цагааннуур			-					-	50.0	50.0	
14	Өлгий	21.5	5.5	27.0		23.8	0.7		288.3	312.8	312.8	

15	Аймгийн ОНХС			-					-	5,381.6	4,981.1	400.5
	НИЙТ ДҮН	21.5	337.1	358.6	27.7	171.2	198.0	147.8	2,075.0	8,001.3	7,601.2	400.5

ХАВСРАЛТ 3:

ОНХСангийн орлогын шилжүүлэг болон урьд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байдал:

Аймаг, сумын ОНХСан	Аймгийн ИТХ-аас баталсан дүн	Аймаг, сумын ИТХ-аас тодотголоор баталсан		Батлагдсан төлөвлөгөө
		Урьд оны үлдэгдлээс	2021 оны татварын орлогыг нэмэгдүүлж баталсан дүнгээс хуваарилсан	
Алтай	162.9			162.9
Алтанцөгц	114.3	11.6		125.9
Баяннуур	134.1			134.1
Бугат	108.5	16.9		125.4
Булган	281.9	173.0		454.9
Буянт	93.5	31.2		124.7
Дэлүүн	293.9			293.9
Ногооннуур	244.5	97.1		341.6
Сагсай	159.5	15.8		175.3
Толбо	144.8			144.8
Улаанхус	214.6			214.6
Цэнгэл	304.3	124.8		429.1
Өлгий	312.8	44.7		357.5
Цагааннуур	50.0			50.0
Аймгийн ОНХС	5,381.6			5,381.6
Дүн	8,001.3	515.1	-	8,516.4

ХАВСРАЛТ 4:

Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл:

Аймаг, сум	Төлөвлөсөн	Хуваарилсан	Илүү, дутуу
Алтай	163.0	163.0	-
Алтанцөгц	114.3	114.3	-
Баяннуур	134.1	134.1	-
Бугат	108.5	108.5	-
Булган	281.9	281.9	-
Буянт	93.5	93.5	-
Дэлүүн	293.9	293.9	-
Ногооннуур	244.5	244.5	-
Сагсай	159.5	159.5	-
Толбо	144.8	144.8	-
Улаанхус	214.6	214.6	-

Цэнгэл	304.3	304.3	-
Өлгий	312.8	312.8	-
Цагааннуур	50.0	50.0	-
Аймгийн ОНХсан	5,381.6	5,381.6	-
Дүн	8,001.3	8,001.3	0.00

ХАВСРАЛТ 5:

Сумуудын Иргэдээс авсан санал асуулгын судалгаа:

№	Аймаг, сум, дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт санал өгсөн иргэдийн тоо	Нийт санал /ажлаар/		Батлагдсан санал		Цуцлагдсан санал	
		цахим	Бүлгийн ярилцагаа	цаасаар		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	3	4	5	6	7=4+5+6	8	9.0	10	11.0	12	13.0
1	Алтай	-	-	4,329	4,329	14	163.0	11	143.3	3	19.7
2	Алтанцөгц			1,363	1,363	11	125.9	11	125.9		
3	Баяннуур			1,320	1,320	41	142.0	26	85.0	15	57.0
4	Бугат			930	930	14	108.5	14	108.5	-	-
5	Булган			1,860	1,860	45	542.0	33	326.0	12	216.0
6	Буянт			1,368	1,368	11	93.5	11	93.5		
7	Дэлүүн			2,940	2,940	38	363.0	31	223.0	7	140.0
8	Ногооннуур	-	-	1,434	1,434	30	268.2	25	268.2	5	
9	Сагсай			4,266	4,266	19	159.5	19	159.5		
10	Толбо	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Улаанхус			5,532	5,532	30	214.9	30	214.9		
12	Цэнгэл			3,434	3,434	41	429.1	41	429.1		
13	Өлгий	298	281	4,671	5,250	141	312.6	38	312.6	103	
14	Цагааннуур			205	205	8	50.0	8	50.0	-	-
	Сумын дүн	298	281	33,652	34,231	443	2,972.2	298	2,539.5	145	432.7

ХАВСРАЛТ 6:

Худалдан авалттай холбоотой судалгаа

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Төлөвлөсөн ажил		Нээлттэй тендер шалгаруулалт					
		Шинэ оны ажил				Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Өлгий аймаг	132	4,156.3	9	1,295.8	58	2,103.2	65	757.3
2	Өлгий сум	32	328.6	1	39.0			30	284.6
3	Алтай	14	162.9	1	76.2	0	0	10	67.0
4	Алтанцөгц сум	10	120.4			1	44.9	9	75.5
5	Баяннуур сум	32	134.1					18	63.9
6	Бугат	14	108.5					14	108.5
7	Булган	37	454.9	1	200.0			36	254.9
8	Буянт сум	10	96.7			2	60.0	8	36.7
9	Дэлүүн	38	293.9			1	28.9	37	265.0
10	Ногооннуур	25	268.2	3	119.1	0	0	21	124.1

11	Сагсай сум	19	159.5			3	79.5	16	80.0
12	Толбо сум	14	144.8					14	144.8
13	Улаанхус сум	21	214.9			2	56.1	15	89.4
14	Цагааннуур	8	47.8					8	47.8
15	Цэнгэл сум	25	304.3					25	304.3
	Нийт дүн	431	6,995.8	15	1,730.1	67	2,373	326	2,703.8